



ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 8/01

Дархан

Г

Т

Хэлтсийн дарга Б.Чинбилэгээр
Урлаг, уран бүтээлийн асуудал хариуцсан
мэргэжилтний албан үүргийг түр орлон
гүйцэтгүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.8 дахь заалт, 43 дугаар зүйлийн 43.2, 43.3.3, 43.4 дэх хэсэг, 57 дугаар зүйлийн 57.1, 57.2.2 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.1, 56.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.5, 16.5.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын 1.1, 2.4-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын Урлаг, уран бүтээлийн асуудал хариуцсан мэргэжилтний сүл гарсан орон тоог нөхөгдөх хүртэл хугацаанд албан үүргийг Соёл, урлагийн хэлтсийн дарга Б.Чинбилэгээр 2024 оны 01 дүгээр сарын 02-ний өдрөөс эхлэн түр орлон гүйцэтгүүлсүгэй.

2. Хэлтсийн дарга Б.Чинбилэгт Урлаг, уран бүтээлийн асуудал хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэх хугацаанд цалин хөлсийг үндсэн цалингийн 40 /дөчин/ хувиар тооцож олгохыг Ерөнхий нягтлан бодогч /Г.Энхжаргал/-д зөвшөөрсүгэй.

3. Урлаг, уран бүтээлийн асуудал хариуцсан мэргэжилтний ажил үүргийг үндсэн албан тушаалаасаа чөлөөлөгдөхгүйгээр албан үүргийнхээ зэрэгцээ түр орлон гүйцэтгэж, үр дүнг хариуцан ажиллахыг Соёл, урлагийн хэлтсийн дарга /Б.Чинбилэг/-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга /С.Туяа/-д даалгасугай.

ДАРГА

Х.СОЁЛ-ЭРДЭНЭ

452402001
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ
ДАРГА